БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2023/92/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Х.Манаргүл<br>Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ **Error! Bookmark not defined.**

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ **Error! Bookmark not defined.**

4.1 Ерөнхий зүйл ........ **Error! Bookmark not defined.**

4.2 Материаллаг байдал ........ **Error! Bookmark not defined.**

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... **Error! Bookmark not defined.**

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**

4.5.1 Завсрын аудитын талаар ........ **Error! Bookmark not defined.**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ **Error! Bookmark not defined.**

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ **Error! Bookmark not defined.**

5.1 Төлбөрийн акт ........ **Error! Bookmark not defined.**

5.2 Албан шаардлага ........ **Error! Bookmark not defined.**

5.3 Зөвлөмж ........ **Error! Bookmark not defined.**

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ **Error! Bookmark not defined.**


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ТОЛБО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.НУРСАУЛЕ ТАНАА

2023.02.20 № 109

танай ____________ -ны № ____________ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хандив тусламжаар 52.0 сая төгрөгийн вакцин, эм, эмнэлгийн хэрэгсэлийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **64,212,965.08** | **107,461,739.68** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 25,408,544.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 25,408,544.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 25,408,544.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 25,408,544.00 |
| **33** | **АВЛАГА** | 33,466,504.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 44,504.00 | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 33,422,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 30,746,461.08 | 82,053,195.68 |
| **351** | **Түүхий эд материал** | 15,443,778.04 | 55,504,707.64 |
| 35130 | Эм боох материал | 15,443,778.04 | 55,504,707.64 |
| **354** | **Хангамжийн материал** | 15,302,683.04 | 26,548,488.04 |
| 35420 | Аж ахуйн материал | 12,389,193.04 | 22,176,193.04 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 347,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,913,490.00 | 4,024,795.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **609,409,582.05** | **676,876,465.25** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 609,409,582.05 | 676,876,465.25 |
| **392** | **Биет хөрөнгө** | 606,105,582.05 | 673,632,465.25 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 492,369,200.00 | 501,369,200.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (29,901,343.80) | (37,979,075.64) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 79,000,522.00 | 79,000,522.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (50,844,652.44) | (56,694,651.48) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 151,215,340.13 | 240,728,345.13 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (63,067,730.59) | (83,038,680.82) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 51,227,683.92 | 59,198,683.92 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (36,218,437.17) | (39,001,877.90) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 24,500,000.00 | 24,500,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (12,175,000.00) | (14,449,999.96) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,304,000.00 | 3,244,000.00 |
| 39301 | Програм хангамж | 850,000.00 | 850,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (690,000.00) | (750,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,144,000.00 | 3,144,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **673,622,547.13** | **784,338,204.93** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **4,108,800.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 4,108,800.00 | - |
| **413** | **Өглөг** | 4,108,800.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 4,108,800.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 4,108,800.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **669,513,747.13** | **784,338,204.93** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 669,513,747.13 | 784,338,204.93 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 228,845,545.08 | 228,845,545.08 |
| 51101 | Өмч: - төрийн | 228,845,545.08 | 228,845,545.08 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 133,140,660.33 | 247,965,118.13 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 133,140,660.33 | 133,140,660.33 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 114,824,457.80 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 307,527,541.72 | 307,527,541.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **673,622,547.13** | **784,338,204.93** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **796,592,886.05** | **863,691,477.99** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **116,775,563.05** | **109,124,770.99** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 116,775,563.05 | 109,124,770.99 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 116,775,563.05 | 109,124,770.99 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 116,775,563.05 | 109,124,770.99 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **679,817,323.00** | **754,566,707.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 479,134,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 479,134,900.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 118,844,713.00 | 1,210,557.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 51,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 117,137,831.00 | 310,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,655,882.00 | 900,557.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 16,721,100.00 | 33,534,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 16,721,100.00 | 33,534,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 65,116,610.00 | 719,822,150.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 65,116,610.00 | 719,822,150.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **696,091,134.57** | **748,867,020.19** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **696,091,134.57** | **748,867,020.19** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 658,491,134.57 | 748,860,623.19 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 426,140,079.00 | 451,087,995.00 |
| 210101 | Үндсэн цалин | 261,876,579.00 | 280,763,214.00 |
| 210102 | Нэмэгдэл | 102,822,300.00 | 106,920,539.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,804,000.00 | 8,037,000.00 |
| 210104 | Урамшуулал | 54,637,200.00 | 55,367,242.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,394,645.00 | 57,199,446.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,474,145.00 | 39,762,371.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,730,100.00 | 4,360,838.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,984,100.00 | 3,488,530.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 746,000.00 | 911,959.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,460,300.00 | 8,675,748.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,245,925.00 | 30,248,103.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,657,625.00 | 1,699,703.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,588,300.00 | 27,765,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 783,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,585,900.00 | 53,288,620.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,845,800.00 | 5,069,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,222,100.00 | 36,038,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,320,700.00 | 3,758,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,375,200.00 | 1,080,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,456,800.00 | 7,342,970.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,365,300.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 81,898,738.96 | 102,178,312.39 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 70,580,118.96 | 84,294,077.39 |
| 210502 | Хоол, хүнс | 8,297,520.00 | 10,494,235.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,021,100.00 | 7,390,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,088,940.00 | 4,990,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 356,940.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 732,000.00 | 4,990,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,384,831.00 | 1,107,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,384,831.00 | 1,107,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 601,700.00 | 402,228.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 300,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 35,600.00 | 13,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 48,300.00 | 48,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 38,000.00 | 9,388.00 |
| 210807 | Газрын төлбөр | 42,300.00 | 31,440.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 77,500.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 36,150,375.61 | 48,357,818.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,194,260.00 | 9,340,697.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 33,956,115.61 | 39,017,121.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 37,600,000.00 | 6,397.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 37,600,000.00 | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 37,600,000.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 6,397.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 6,397.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **100,501,751.48** | **114,824,457.80** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 25,902.20 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 25,902.20 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (25,902.20) | - |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **100,475,849.28** | **114,824,457.80** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **646,395,323.00** | **787,988,707.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **646,395,323.00** | **787,988,707.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 479,134,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 479,134,900.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 118,844,713.00 | 1,210,557.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 51,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 117,137,831.00 | 310,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,655,882.00 | 900,557.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 16,721,100.00 | 33,534,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 16,721,100.00 | 33,534,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 31,694,610.00 | 753,244,150.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 31,694,610.00 | 753,244,150.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **638,608,323.00** | **713,223,463.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **638,608,323.00** | **713,223,463.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **601,008,323.00** | **713,217,066.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 427,712,012.00 | 451,087,995.00 |
| 210101 | Үндсэн цалин | 263,448,512.00 | 280,763,214.00 |
| 210102 | Нэмэгдэл | 102,822,300.00 | 106,920,539.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,804,000.00 | 8,037,000.00 |
| 210104 | Урамшуулал | 54,637,200.00 | 55,367,242.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,394,645.00 | 57,154,942.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,474,145.00 | 39,762,371.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,730,100.00 | 4,360,838.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,984,100.00 | 3,488,530.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 746,000.00 | 867,455.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,460,300.00 | 8,675,748.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,245,925.00 | 30,595,603.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,657,625.00 | 1,699,703.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,588,300.00 | 28,112,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 783,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 37,340,600.00 | 58,622,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,845,800.00 | 5,069,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,113,300.00 | 40,147,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,320,700.00 | 3,758,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 1,445,200.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,615,600.00 | 1,154,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 8,494,150.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 61,644,410.00 | 96,646,401.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 47,375,810.00 | 72,482,861.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,157,500.00 | 11,605,540.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,111,100.00 | 12,558,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,374,940.00 | 5,535,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 642,940.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 732,000.00 | 5,535,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,384,831.00 | 1,107,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,384,831.00 | 1,107,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 601,700.00 | 402,228.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 300,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 35,600.00 | 13,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 48,300.00 | 48,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 38,000.00 | 9,388.00 |
| 210807 | Газрын төлбөр | 42,300.00 | 31,440.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 77,500.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,309,260.00 | 12,064,697.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,309,260.00 | 12,064,697.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **37,600,000.00** | **6,397.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 37,600,000.00 | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 37,600,000.00 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 6,397.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 6,397.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,787,000.00** | **74,765,244.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **7,787,000.00** | **49,356,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,787,000.00** | **49,356,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 7,787,000.00 | 49,356,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,787,000.00 | 49,356,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(7,787,000.00)** | **(49,356,700.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 25,408,544.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 25,408,544.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **133,140,660.33** | 669,513,747.13 |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **133,140,660.33** | 669,513,747.13 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **133,140,660.33** | **669,513,747.13** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 114,824,457.80 | 114,824,457.80 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **247,965,118.13** | 784,338,204.93 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 816,386,500.00 | 761,673,209.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 816,386,500.00 | 761,673,209.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 816,386,500.00 | 761,673,209.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 479,149,100.00 | 451,087,995.00 |
| 210101 | Үндсэн цалин | 281,835,900.00 | 280,763,214.00 |
| 210102 | Нэмэгдэл | 111,221,200.00 | 106,920,539.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,037,000.00 | 8,037,000.00 |
| 210104 | Урамшуулал | 78,055,000.00 | 55,367,242.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,893,500.00 | 57,154,942.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,347,600.00 | 39,762,371.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,636,500.00 | 4,360,838.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,709,200.00 | 3,488,530.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 927,300.00 | 867,455.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,272,900.00 | 8,675,748.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,705,700.00 | 30,595,603.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,400,800.00 | 1,699,703.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,304,900.00 | 28,112,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,000,000.00 | 783,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 59,696,900.00 | 58,622,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,099,900.00 | 5,069,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,147,000.00 | 40,147,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,900,000.00 | 3,758,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,500,000.00 | 1,154,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,050,000.00 | 8,494,150.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 111,861,800.00 | 96,646,401.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 82,998,900.00 | 72,482,861.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,477,200.00 | 11,605,540.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 14,385,700.00 | 12,558,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 60,402,000.00 | 54,090,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 43,750,000.00 | 41,335,700.00 |
| 210602 | Тавилга | 6,800,000.00 | 3,370,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,852,000.00 | 9,385,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,180,000.00 | 1,107,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,180,000.00 | 1,107,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 524,200.00 | 402,228.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 300,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 35,600.00 | 13,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 48,300.00 | 48,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 38,000.00 | 9,388.00 |
| 210807 | Газрын төлбөр | 42,300.00 | 31,440.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,973,300.00 | 11,965,140.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,973,300.00 | 11,965,140.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 816,386,500.00 | 787,081,753.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 34,637,700.00 | 33,527,603.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 34,637,700.00 | 33,527,603.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 781,748,800.00 | 753,554,150.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 781,748,800.00 | 753,554,150.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 25,408,544.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 34 | 32 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 26 | 21 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7 | 10 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **25** | **34** |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 19.0 | 25.0 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 6.0 | 8.0 |
| 650010 | Гэрээт ажилтан | | 1.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **118,844,713.00** | **1,210,557.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **118,844,713.00** | **1,210,557.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 81,244,713.00 | 1,210,557.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 54,699,812.00 | - |
| 210101 | Үндсэн цалин | 33,265,212.00 | - |
| 210104 | Урамшуулал | 21,434,600.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,038,045.00 | - |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,038,045.00 | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 256,825.00 | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 256,825.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,363,700.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 392,300.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,321,400.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 100,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 550,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 15,731,500.00 | 310,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 14,311,500.00 | 310,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,300,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 120,000.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,874,831.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,874,831.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 280,000.00 | 900,557.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 280,000.00 | 900,557.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 37,600,000.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 37,600,000.00 | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 37,600,000.00 | - |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 118,844,713.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 118,844,713.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 51,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 117,137,831.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,655,882.00 | - |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 25,408,544.0 |

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгуулагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн зорилго нь: Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, чанартай, хүртээмжтэй, чирэгдэл хүлээгдэлгүй үр дүнтэй үзүүлэх

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна.Үүнд:

- Хамт олны оролцоог хангах
- Үйлчлүүлэгчдийг дээдлэх
- Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах
- Ил тод нээлттэй байх
- Шинэ санаа санаачилгыг дэмжих, үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, эмнэлгийн тусламжийн тухай хууль, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн яамны салбарын НББ-ийн бодлогын баримт бичиг батлах тухай” 2010 оны 138 дугаар тушаалаар баталсан НББ-ын бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 110.7 сая төгрөгөөр буюу 16.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 25 408.5 | 25 408.5 |
| Авлага | 33 466.5 | - | (33 466.5) |
| Бараа материал | 30 746.5 | 82 053.2 | 51 306.7 |
| Үндсэн хөрөнгө | 609 409.6 | 676 876.5 | 67 466.9 |
| **Нийт хөрөнгө** | **673 622.5** | **784,338.2** | **110 715.7** |
| Өр төлбөр | 4 108.8 | - | (4 108.8) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 669 513.7 | 784 338.2 | 114 824.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **673 622.5** | **784 338.2** | **110 715.7** |

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Мөнгөн хөрөнгийн данс оны эхэнд үлдэгдэлгүй байсан ба оны эцэст 25.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 33.5 сая төгрөг буурсан нь Ковид-19 тэй холбоотой Эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилтийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82.1 сая төгрөг болж 51.3 сая төгрөгөөр өссөн. Төсвийн хөрөнгөөр 155.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн даргын тушаалаар 51.9 сая төгрөгийн вакцин, эм, эмнэлгийн хэрэгсэлийг шилжүүлэн авч данс бүртгэлд тусган, 155.7 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 908.8 сая төгрөг болж 106.5 сая төгрөгөөр өссөн нь 49.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газар, сумын ОНХСан болон хувь хүмүүсээс бүгд 57.1 сая төгрөгийн барилга, машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Тайлант онд 114,8 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 114,8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 809,9 сая, нийт зарлагыг 809,9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, НДШимтгэлийн зардал 8.7 сая, хангамж бараа материалын зардлыг 12.4 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3.0 сая, норматив зардал 25.1 сая, эд хогшил урсгал зардал 53.9 сая, бараа үйлчилгээний бусад

зардал 0.3 сая төгрөгөөр бүгд 103.4 сая төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 706.5 сая төгрөгөөр баталсан байна.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны анх батлагдсан төсөв 706,5 сая төгрөг ба тодотгосон төсөв 816.4 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсанаас 109.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үүнд: Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 17.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, норматив зардал 25.1 сая, хангамжийн материал 12.4 сая, эд хогшил урсгал засварын зардлыг 53.9 сая, бараа үйлчилгээний бусад зардал 1.5 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ гэсэн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 784.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 31.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүгд 816.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 756.5 сая, орон нутгийн төсвөөс 30.6 сая бүгд **787.1** сая төгрөгийн санхүүжилт олгож гүйцэтгэл 96.4 хувьтай байгаа нь 0.6 хувь буюу 29.3 сая төгрөгөөр санхүүжилт дутуу авсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 96.8 хувь 761.7 сая төгрөг ба хэмнэгдсэн 25.4 сая төгрөгийг байгууллагын харилцах дансны үлдэгдэлд байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардал бүрээр задалж харуулахад цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардал 451.1 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 57.2 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 30.6 сая, хангамж, бараа материалын зардал 58.6 сая, нормативт зардал 96.6 сая, эд хогшил, урсгал засварын зардал 54.1 сая, бусад бараа үйлчилгээний зардал 13.5 сая бүгд 761.7 сая төгрөг байна.

Нийт төсвийн зарлагын 59.2 хувийг цалингийн зардал, 7.5 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 4.0 хувийг тогтмол зардал, 7.7 хувийг хангамж, бараа материалын зардал, 12.7 хувийг норматив зардал, 7.1 хувийг эд хогшил, урсгал засварын зардал 1.8 хувийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нийтлэг үйлчилгээ | 31,705.7 | 30,595.6 | (1,110.1) | 96% |
| 2 | Нэг иргэнд ногдох нормативаар | 405,716.1 | 403,211.0 | (2,505.1) | 99% |
| 3 | үндсэн мэргэжлийн тусламж үйлч | 334,170.7 | 283,072.6 | (51,098.1) | 85% |
| 4 | Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан | 44,794.0 | 44,794.0 | - | 100% |
| | Дүн | 816,386.5 | 761,673.2 | (54,713.3) | 93% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас эм, бакцин тарих 0.3 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 0.9 сая бүгд 1.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий ймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 696.0 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд 20.4 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийг шууд гэрээгээр худалдан авч төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлээгүй байна. Энэхүү зөрчилд албан шаардлага өгөгдсөн.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь 2022 онд нийт 786.7 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудит хийгдээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар эргэлтийн эмийн сангийн бүртгэл, тооцоо зохих журмаар явагдаагүй, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллаагүй зэрэг зөрчилүүдийг арилгуулах талаар албан шаардлага өгсөн. Эмийн эргэлтийн сангийн 2022 оны тайлан гаргаж ирүүлсэн боловч Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар баталсан "Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж Толбо сумын ЭМТ-ийн төсвийн болон орон нутгаас авсан санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй, зөвхөн санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **152.1** сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 152.1 сая төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

**5.1 Төлбөрийн акт**

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

**5.2 Албан шаардлага**

Албан шаардлага байхгүй

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр "Мармара Өлгий" ХХК-аас 20.4 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийг шууд гэрээгээр худалдан авч төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлээгүй байна.

*1.1 Өгсөн зөвлөмж:*

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах.

***2.Үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 121 нэр төрлийн 119.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:*

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэсэн заалтыг мөрдөж, ээлэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох.

***3. Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэхтэй холбоотой асуудал***

*3.1. Илрүүлэлт:*

Албан томилолт, нормын хувцас, сургалтын төлбөр зэрэг зардлуудын нийт 12.2 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

*3.2 Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх заавар аргачлалын хэрэгжилтийг хангаж ажиллах.

***4.Эмийн эргэлтийн сангийн холбоотой асуудал***

*4.1. Илрүүлэлт:*

Эрүүл мэндийн төвийн дэргэдэх Эмийн эргэлтийн сангийн 2022 оны тайланд эмийн санч эмийн бөөний төвүүдээс авсан эмийн үнэд тодорхой хэмжээний үнэ нэмж зарцуулсан гэж тайлан гаргасан, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар баталсан “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ыг мөрдөж ажиллаагүй.

Эрүүл мэндийн төвийн эмийн санч Эмийн эргэлтийн сангийн ажлыг давхар хийж дотор эмийн сан болон Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг нэг өрөөнд хамт явуулдаг байна.

*4.1 Өгсөн зөвлөмж:*

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар баталсан “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ыг мөрдөж ажиллах, Эмийн эргэлтийн санг дотор эмийн сангаас тусгаарлах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн үнийг зохих журмын дагуу шинэчлэн тогтоогоогүй | 1 | 119572.3 | | | | | | | | | 1 | 119572.3 |
| **Дүн** | **1** | **119572.3** | | | | | | | | | **1** | **119572.3** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж | 1 | 12210.0 | | | | | 1 | 12210.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **12210.0** | | | | | **1** | **12210.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цахим худалдан авалт хийхгүй, шууд гэрээгээр худалдан авсан | 1 | 20350.0 | | | | | 1 | 20350.0 |
| Дүн | 1 | 20350.0 | | | | | 1 | 20350.0 |
| **Нийт дүн** | **1** | **20350.0** | | | | | **1** | **20350.0** |